

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”**

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234727

**МОРИН ХУУРЫН НЭРШЛИЙН ХУВЬСАЛ, ӨӨРЧЛӨЛТӨД ХИЙСЭН
ЗАРИМ АЖИГЛАЛТ**

П.Даваапил

Үндэс

Түлхүүр үг: Морин хуур, суух хуур, хун хуур, икэл, луу хуур, цоор, арслан хуур

Оршил

Монголын хөгжмийн нэр томьёо, тэр дундаа хөгжмийн зэмсгийн нэр томьёог Г.Бадрах, Ж.Бадраа, С.Баянжаргал, Л.Хэрлэн, Ж.Чулуунцэцэг зэрэг эрдэмтэд, домог түүхтэй холбоотой баримтуудыг нь С.Дулам, Л.Эрдэнэчимэг, Л.Оюунчимэг зэрэг эрдэмтэд судалжээ. Ингэхдээ тухайн тухайн хөгжимдүүр нь ямар ангилалд багтах, ямар хийц бүтэцтэй болох, ямар домогтой холбоотой үүссэн зэргийг нь голчлон тэмдэглэсэн байх бөгөөд нэршил нь ямар учиртай, хаанаас гаралтайг нь тэр бүр тодорхой тайлбарлаагүй байна. Гэвч эдгээр судлаачдын бүтээлүүд дэх морин хуур, түүний хөгжлийн явцад бий болсон өөр өөр нэршлүүдийг мөн тайлбарласан байна. Эдгээр тайлбаруудыг хооронд нь жишин үзэх, аль цаг үед хамаатахыг нь хийц, бүтэц, орчин ахуй, нийгмийн хөгжилтэй уялдуулан авч үзье.

Үндсэн хэсэг

Морин хуур, түүний өөрчлөлт, шинэчлэлтийн явцад дараах нэршлүүд бий болжээ. Үүнд: Суух хуур, давсан хуур, икэл, икил, игил, ихэл, ааган икэл, матар хуур, хунт хуур, аралт хуур, арслан хуур, гарди хуур, луун хуур, морин хуур, үйлдвэр хуур, хил, их хуур гэх мэт. Эдгээр нэршлүүдийг адил төстэй шинжээр нь нэгдүгээрт, суух хуур, давсан хуур, шанаган хуур, хоёрдугаарт, икэл, икил, игил, ихэл, ааган икэл, экэл, гуравдугаарт матар хуур, хунт хуур, аралт хуур, арслан хуур, гарди хуур, луун хуур, морин хуур, үйлдвэр хуур, дөрөвдүгээрт, хил, их хуур гэсэн дөрвөн бүлэгт хувааж тус бүрт нь дэлгэрүүлэе.

Суух хуур, давсан хуур, шанаган хуур: Ж.Бадраа “Хилт чавхдаст хөгжмийн зэмсэг. Булган аймгийн Тэшигийн буриадууд түгээмэл хэрэглэдэг. Жижиг дөрвөлжин царын нь үхрийн нэг давсаг (давсан)-аар ар өвөргүй бүрсэн байдаг. Нэг юм уу хоёр хялгасан чавхдас нь ижил эгшгийн хөгтэй. Нутгийнхан суух хуур гэж нэрлэдэг. Суух гэдэг нь давсангийн буриад нэр” (1998:138) гэжээ.

Хуурын эртний нэгэн төрөл “суух хуур” буюу “цуух хуур”, “давсан хуур” нь үүсэл гарвацийн хувьд монголын нумт чавхдаст хөгжмийн хамгийн эртнийх нь болно. Суух хуур нь ганц чавхдастай, хуурдахдаа хуурч хоёр хөлөө жийж, баруун хөлийнхөө гутлын хониоор дээр хуурын цуурайн хайрцгийг тогтоон байрлуулж, толгойн хэсгийг зүрхэн тус газар тулж, зүүн гараар чавхдасыг дарж, баруун гараар нумыг татаж эгшиглүүлэн тоглодог онцлог бүхий хөгжим юм. Суух хуурын цуурайн хайрцгийн нүүрэн хэсгийг үхрийн давсгийн гэр эсвэл дөнгөж төллөсөн үнээний ихэсийн хальсаар бүрж, морины сүүлний хялгасан чавхдас, нумаар хөрөөдөн эгшиглүүлдэг байна, энэ хуур буриадуудын дунд түгээмэл хэрэглэгддэг байсан бөгөөд одоо мартагдан гээгдэхэд хүрээд байна. (Хэрлэн, 2009:33) Соёл, урлагийн тайлбар толийн дөрөвдүгээр боть болох “Хөгжим”-ийн ботид “Царыг давсаар бүрж хийдэг “Давсан хуур”, “Давсан хуур”-ыг буриадууд “Суух хуур”, “Суухан хуур” хэмээдэг. Суух хуурын цуурайн хайрцгийн нүүрэн хэсгийг үхрийн давсаг эсвэл дөнгөж тугалласан үнээний ихэсийн хальсаар бүрж хийдэг. Адууны сүүлний 60-80 ширхэг хялгасаар хийсэн ганц чавхдастай. Чавхдасыг бага наймцын фа /f/ эгшгээр хөглөх бөгөөд эгшиглэгээний цараа багатай. Морины сүүлний хялгасаар урласан нумаар хөрөөдөн эгшиглүүлдэг. Хуурдахдаа хуурч нэг хөлөө нугалж нөгөө хөлөө жийж, жийсэн хөлийг дээш ээтийлгэн дээр нь хуурын цуурайн хайрцгийг тогтоон байрлуулна. Толгойн хэсгийг зүрхэн тус газар тулж, зүүн гараар чавхдасыг дарж, баруун гараар нумыг татна. Суух хуурын царыг байрлуулах хөлийн ээтийсэн хэсгийг буриадууд “Хөлийн гануу” хэмээдэг. Суух хуураар дуучинтай хамсран хуурдахдаа дуучны хоолойд тохируулан хөг сольж болдог” (Соёл, урлагийн их сургуулийн Соёл, урлаг судлалын хүрээлэн, 2018:305-307) гэжээ.

Шанаган хуурыг Ж.Бадраа “Шанаган хуур бол одоогийн баруун Монголын олон ястан ардын хэрэглэж байгаа ааган товшуур, хэлдүүр, дөрвөлжин цартай товшуурын нэгэн зүйл байжээ. Хожим үес нумтай болж хун буюу гарди толгойгий нь морин толгойгоор сольсноор морин толгойтой хуур буюу товчоор морин хуур гэх болжээ” (1998:91) хэмээсэн байна. Л.Хэрлэн “Монголын хөгжмийн зэмсгийн нэгэн зүйл болох морин хуур хөгжмийн анхдагчийн нэг шанаган хуур хэмээх зэмсэг айргийн утгуурт хялгас татан дуугаргаж хэрэглэх болсноор ийнхүү шанаган хуур үүсэж нэрлэгдсэн” (2009:36-37) гэжээ. Эндээс ажиглавал суух хуур нь нэлээд эртний нэр бөгөөд буриадууд давсан хуур хэмээн нэрлэдэг болох нь тодорхой байна. Шанаган хуур нь мөн нь ахуй амьдралаас үүдэн гарсан эртний хэлбэр байна. Эдгээр нь хэлбэр хийц, цараа, хийх арга барилын хувьд монголчуудын энгийн ахуй амьдралтай холбоотой байна. Яваандаа улам төгөлдөржин уг хуурыг хэрэглэх нь түгээмэл биш болж уг нэршил нь бараг хэрэглэгдэхгүй болж сурвалж бичгүүд болон буриадуудын дунд уламжлагдаж байсан ч эдүгээ эртний уг янзаар нь дахин урлан хэрэглэх болсноор эдгээр нэршлийг дахин хэрэглэх боллоо.

Ааган икэл, игил, икил, икэл, ихэл, экэл: Эдгээр нэршлүүдийн хамгийн эртнийх нь ааган икэл бололтой. “Икэл” хэмээх нэршлийн “к” гийгүүлэгч “х, г” гийгүүлэгчтэй сэлгэж “ихэл”, “игил”¹, “э” эгшиг нь “и” эгшигтэй сэлгэж

¹ Ж.Бадраагийн 1998 онд хэвлэгдсэн “Монгол ардын хөгжим” номын 140-р талд “Тува ихэлийн нэр. Хоёр чавхдаст хилт хөгжмийн зэмсэг. Гонзгой дугуй модон цартай, арьсан бүрээстэй. Дөрөвцийн хөгтэй” гэж тайлбарлажээ.

“икил”² зэрэг нэршлүүд үүссэн байна. Угтаа “икэл”, “ихэл” хэмээх нэршил нь түгээмэл байна. Ж.Бадраа Ааган икэлийг “Баруун Монголын дүгрэг цартай хилт хуурын нэр. Угтаа аягыг ширлэж хуурын цар буюу баруун монголчуудынхаар толгой болон эш шургуулж хялгас татан, хуурдах зэмсэг хийж байснаас ааган (аяган) толгойтой (цартай) икэл (ихэл) гэж нэрлэсэн учиртай” (1998:133) гэжээ. Соёл, урлагийн тайлбар толийн дөрөвдүгээр боть болох “Хөгжим”-ийн ботид “Урианхай, Торгууд зэрэг баруун монголчууд томоохон модон аягыг ширлэж иш шургуулж хялгас татан хуурдах зэмсэг хийж түүнийхээ царын хэлбэрээр нь аяга буюу ааган икэл хэмээн нэрлэдэг байжээ” (2018: 117) гэснээс үзвэл баруун монголчуудын дунд “икэл” хэмээн нэрлэж байжээ. Энэ нь тэдний хэл аялгуутай холбоотой байна. Харин “ихэл” хэмээх нь хөгжмийн хэл, аялгуу түүний илэрхийлэлтэй холбоотой төдийгүй, энэ хөгжимдүүрийн үүсэлтэй холбоотой домгийн өгүүлэмжтэй уялджээ. Тодруулбал, Ж.Бадраа “Баруун Монголын ихэд хуурын халх дуудлага. Морин хуурын нам. Гагцхүү морин толгойгүй. Гилбэр буюу эсвэл чандмань толгойтой байдаг. Хэмжээ хийц янз бүр. Бүдүүн буюу арга чавхдас нь биен талд байдаг. Голцуу тавц, заримдаа дөрвөцийн хөгтэй. Хүний хэлийг бага хэл, хөгжмийн хэлийг их хэл гэх учиртай тул их хэл гэсэн үгнээс нэр нь гаралтай гэсэн домог тайлбар бий. Ихлийн татлага гэж ихэлд зориулсан олон зүйл аялгуу байдаг” (1998:141). Л.Хэрлэн “Ихэл³ хөгжим нь морин хууртай харьцуулбал цар нь жижиг, иш нь нэлээд урт нарийхан, богино нумтай, толгойн хэсэгтээ элдэв амьтны сийлбэр байхгүй, жижиг тэвхтэй хөгжим юм. Гол төлөв баруун монголчуудын дунд өргөн дэлгэрсэн татлага татаж эгшиглүүлдэг байна” (2009:34). С.Дулам “Монгол домог зүйн дүр” номдоо “Баруун монголчууд дээр дурдсанаар морин хуурыг “экэл” (ekil) хэмээн нэрлэдэг бөгөөд энэ нэрийн тухай сонин тайлбар бий. Малчин ардууд үр төл нь үхэж үрэгдсэн эх малыг хайдагшуулах юм уу, гологдсон төлийг эхэд нь авахуулахдаа ямагт хуур хөгжим татаж аялгуулан дуулдаг байна. Тэгээд хүний хэлээр үглэн ятгаж чадахгүй байхад хөгжмийн хэлээр адгуус малыг ч уяраан ятгаж болдог юм байна гэж ухаараад хүний хэл бол “бага хэл”, хөгжмийн хэл бол “их хэл” гэсэн утгаар “экэл” нэрийг өгсөн гэлцдэг” (2009:279) хэмээсэн нь хөгжмийн хэл гэгч хүний хэлнээс илүү өргөн агуулгатай болохыг эрт дээр үеэсээ хэлэлцэж байсныг илтгэж байна.

Аралт хуур, арслан хуур, гарди хуур, матар хуур, үйлдвэр хуур, хунт хуур, луун хуур, морин хуур, цоор: Ж.Бадраа “Монгол ардын хөгжим” номдоо “Зүүн Монголчуудын хийлийг нэрлэх нэр. Арал гэдэг нь хуурын эшийг хэлдэг юм” (1998:134) гэжээ. Эндээс үзвэл энэхүү нэршил нь зүүн монголчуудын дунд хэрэглэдэг нэршил бөгөөд хуурын арал буюу ишинд тулгуурлан нэрлэсэн нэр байна. Харин “Хоёр хялгасан чавхдастай хилт хөгжмийн зэмсгийн нам буюу

² Ж.Бадраагийн 1998 онд хэвлэгдсэн “Монгол ардын хөгжим” номын 140-р талд “Баруун Монголд ихэл хуурыг дуудах нэр. Уулын Алтайнхан икили гэдэг” хэмээжээ.

³ Морин хуур хөгжимтэй нэгэн төрөл зүйл болох икэл хөгжмийн тухай нэгэн домог байна. “Өрөөлтэй шаргал” гэдэг татлага аянд энэхүү икэл хөгжмийн тухай өгүүлсэн нь бий. Хошуу нутаг алгасуулж хол газар нэгэн хүнд хурдан удмын шарга морийг худалджээ. Гэтэл тэр шарга морь хэд хоногийн дараа уяан дээрээ ирчихсэн зогсож байжээ. Буцаж ирсэн морио эзэн нь хараад хүнд өгсөндөө харуусч ижил сүрэгт нь тавьж их хэлээр нь магт гэжээ. Ингээд хуур хөгжим хийж аялгуу татаж магтаал дуулжээ. Тэрхүү хөгжмөө “их хэл” гэж нэрлэсэн нь яваандаа ихэл гэж нэрлэгдэх болсон байна.

шанаган хуурын нэгэн зүйл. Арслан толгойтой учир ийм нэрлэжээ” (1998:134). “Эртний босоо ятга, шанаган хуурын толгойд гарди сийлж байснаар гарди хуур гэдэг байжээ. Манай эриний 6-р зуунд холбогдох дунхуаны агуйн хананд гарди толгойтой босоо ятгын зураг байдаг. 17-р зуунд холбогдох Өндөр гэгээн Занабазарын өөрийн зурагт гарди толгойтой шанаган хуурын зураг бий” (1998:137). “Хоёр хялгасан чавхдастай, хилт хөгжмийн зэмсгийн нам буюу шанаган хуурын нэгэн зүйл. Матар хэмээх эвэргүй луу хэлбэрийн толгойтой нь нэлээд эртний бөгөөд хун толгойтой хуурын дараач үеийн уламжлалт хийц бололтой” (1998:142). “Нэгэн зүйлийн шанаган хуур. Цары нь ард хунгийн жигүүр сийлж эш өөд нь хүзүү нь эргэсэн сийлбэртэй ийм шанаган хуур Сайн ноён хан аймгийн Илдэн бэйлийн ордонд байжээ”. Л.Хэрлэн “Монголын хөгжмийн зэмсгийн соёл” номдоо “Луун толгойт хуур нь бусад хуурын адил нумаар хөрөөдөж хөгжимдөх ба толгойн хэсэгт луу сийлж хийснээрээ ялгагдана. Мөн ихэвчлэн цар нь дугуй хэлбэртэйгээс гадна бусад хуурын төрлөөс нэлээд том, урт хэлбэртэй байна. Хөгжмийн түүхийн эхэн үед ширэн цартай байснаа сүүл рүүгээ модон цартай болжээ” (2022:76) гээд Монголын театрын музейн сан хөмрөгт буй луун толгойтой хууруудын талаар дэлгэрүүлэн өгүүлжээ. Ж.Чулуунцэцэг “Монголын уламжлалт хөгжмийн зэмсэг судлал” номдоо “Эрт үед Монголчууд морин хуурыг хун хуур гэж байсан., Ийнхүү дээр өгүүлсэн хун толгойтой хуур нь өөрчлөгдсөөр шанаган хуур, матар хуур, арслан хуур, луу хуур, морин хуур гэхчлэн хувирч өнөө бидний үед уламжлагдан иржээ” (2008: 94) гээд тус бүрд нь дэлгэрүүлж тайлбарлаагүй байна. Эндээс харвал хуур хөгжмийн толгойг янз бүрийн амьтны толгойгоор чимж байснаас дээрх нэршлүүд бий болжээ.

Морин хуурыг “Хоёр хялгасан чавхдастай хилт хөгжмийн зэмсэг. Морин толгойтой хуур гэсэн утгатай. Бас хил буюу татуураар нь хилт хуур гэдэг. Угтаа хил гэдэг нь татуурын хялгас буюу хөвчийн нэр. Татуурын моды нь нум буюу дүнж гэдэг. Гэвч баядад татуурыг бүхэлд нь нум, дөрвөдөд хөвч гэх мэт нутаг нутагт янз янз нэрлэх учир бий. Дээр үеэс одоогийн хийл буюу хуучрыг морин хуур гэж, одоогийн морин хуур шанаган цартай байснаар шанаган хуур гэж байсан түүхтэй. Морин хуур арга буюу монгол хөг гэх тавцын хөг, билиг буюу солгой хөг, мөн цахар хөг гэх дөрөвцийн хөг хоёр зүйл хөгтэй. Морин хуурд зориулсан “Жонон хар морины явдал” буюу хураангуйлан “Жонон” гэдэг олон зүйл татлага бий. Тэдгээр нь нутаг нутгийн өвөрмөц барил зохиомжтой. Морин хуурыг гоцлолоос гадна уртын дууны хамсрал, монгол ардын уламжлалт бичил чуулга, мөн найрал хөгжимд чухал үүрэгтэй хэрэглэдэг. Морин хуурын нарийн хийцэд монголчуудын өнө эртний уламжлалт ур ухаан шингэсэн хөгжлийн урт түүх тодордог” (1998:142-143). Соёл, урлагийн тайлбар толийн дөрөвдүгээр боть болох хөгжмийн ботид “Монгол ардын нумт хөгжимдүүр. Хуурын толгойд ихэвчлэн морины толгойн дүрсийг сийлдэг бөгөөд хун, луу гэх мэт амьтны толгойн дүрсийг ч сийлсэн нь бий” (2018:162). Ж.Бадраагийн “Монгол ардын хөгжим” номд “Үйлдвэр хуур”⁴ гэсэн нэр томъёо байх бөгөөд энэ нь орчин цагийн модон цартай морин хуурыг хэлжээ. Мөн өвөрмонголын нутаг бүрд өөр өөр нэртэй байсныг Мэргэжих, Доржраа, Баянжаргал нар “Хорчины зүүн биеэр

⁴ Ж.Бадраагийн 1998 онд хэвлэгдсэн “Монгол ардын хөгжим” номын 140-р талд “Шинэчилсэн хийцийн модон цартай морин хуурын нэр” гэжээ.

уламжилж ирсэн нэг зүйлийн морин хуурыг тэндэх хүмүүс “цоор” гэж нэрлэдэг. Шилийн голын цахар зэрэг газар орноор морин хуурыг “хийл хуур” гэнэ. Энэ хоёр зүйлийн морин хуур нь бүтцийн талаар үндсэндээ адил, гэвч дотор гаднах утасны байршил, хөглөх арга барил, хуурын гадар хэлбэр маяг нь харин ялгаатай байдаг” (1997:5) хэмээн өгүүлсэн байна.

“Морин хуур” гэх нэршлийг орчин цагийн нэвтэрхий толь, тайлбар толиудад ерөнхий түгээмэл нэр мэтээр толгойлон тайлбарлаж дээрх хунт хуур, матар хуур, гарди хуур зэргийг энэ толгой үгийн агуулгад багтаан тайлбарласан байна. Энэ нь эдүгээ хамгийн түгээмэл хэрэглэгдэж байгаатай нь холбоотой байна. Гэсэн хэдий ч нэршлийн хувьд ингэж “Морин хуур” гэх агуулгад багтаан тайлбарлах нь өрөөсгөл байна. Учир нь одоо цагт гарди толгойтой хуур, матар толгойтой хуур, хун толгойтой хуурын дахин шинэчлэн урлаж хэрэглэх болсон тул эдгээр хуурыг гарди хуур, матар хуур, хун хуур гэж нэрлэж хэрэглэх нь зүйтэй. Морин хуур хэмээх нь морин толгойтой урладаг болсонтой холбоотой болохоос хуурын хуурын эртний нэр биш билээ.

Хил, их хуур: Ж.Бадраа “Хуур хийл, ятгалиг мэт хөгжмийн зэмсгийн чавхдасыг хөрөөдөн эгшиглүүлэх нумын нэр. Хялгастай язгуур нэг болох нь магад” (1998: 148) гэжээ. Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь”-доо хил хэмээхийг хоёр салаа утгаар тайлбарласан байх бөгөөд хоёр дахь утга нь “Хөгжмийн чавхдас хөрөөдөх нум” (1966:677) хэмээн тайлбарлажээ. Ингэхлээр “хил” гэгч нь хуур хөгжмийн дуугаргах нумыг хэлж буй нь тодорхой байна.

Ж.Бадраа “Орчин үеийн ардын найрал хөгжимд туйлын их гарын морин хуур. Зогсоогоор хөгжимддөг. Дөрөвцийн хөгтэй. Ахмад наймцыг ми-гээс бага наймцыг си-бемоль хүртэл эгшиглүүлэх хүртэл цараатай. Өрнөдэхний контрабастай дүйдэг” (1998:140) хэмээжээ. Ж.Чулуунцэцэг “Анхны их хуурыг 1960 оны 6-р сард Ц.Доржсүрэн, УГЗ Ү.Чуваамэд урлаач Дү-Ян-Жин нар хамтран бүтээжээ. Харин энэ хуур ямар хэлбэр дүрстэй, хөг дуурьслын багтаамж нь ямар байхыг Төрийн хошой шагналт, Ардын жүжигчин Л.Мөрдорж зааж, зөвлөжээ. Их хуур нь морин хууртай адил. Харин овор ихтэй, хоёр чавхдас нь хоорондоо цэвэр тавцын зайн хөгтэй байв. 1960 оны өвөл Л.Мөрдорж багш их хуурын хөг, дуурьслын багтаамжийг боловсронгуй болгон өөрчлөх санал гаргаж Фа-суб /F-V/ чавхдастай болгосон нь найрал хөгжмийн суурь хөг, эгшиглэгээнд зохицолгоо сайтай болж эдүгээ энэ хөгөө хадгалсаар байна” (2008:109-110). Л.Хэрлэн “Их хуур хөгжим нь үндэсний найрал хөгжимд гадаад, дотоодын хөгжмийн зохиолчдын бүтээлүүдийг хөгжимдөхөд суурь өнгө тоглох, уран бүтээлийн зохиомжийн найруулгад зөв зохистой өнгө шаардлагатайн улмаас шинэчлэн бүтээсэн хөгжмийн зэмсэг юм” (2009:50-51). Эндээс үзвэл “их хуур” нь морин хуураас нэлээд ялгаатай орчин цагийн найрал хөгжимд гадаад дотоодын аялгууг хөгжимдөхөд нэн шаардлагатай байсан тул шинээр урласан нэршлийн хувьд өөрчлөгдөөгүй шинэхэн хөгжимдүүр байна.

Дүгнэлт

Морин хуур хэмээх нэр нь нэлээд сүүл үед морин толгойтой үйлдэх нь түгээмэл болсон тул ийн нэрлэсэн нэршил байна. Эрт үед арслан, гарди, хун, матар, луу зэрэг амьтдын толгойтой болон ямар нэгэн амьтны толгойгүй гилбэр хэлбэртэй ч урладаг байжээ. Тиймээс “Хуур” хэмээх нь ерөнхий

нэршил бөгөөд толгойг нь ямар амьтны дүрстэй хийснээс хамаарч өөр өөрөөр нэрлэгддэг байна. Хэлбэрийн хувьд ч шанага, аяга, айргийн хутгуур, давсаг зэрэг энгийн ахуй амьдралд ойрхон эд зүйлсийг цар болгон ашиглаж давсаг, ихэс, шир зэргээр бүрж дуугаргадаг байснаас үүдэн давсан хуур, шанаган хуур, ааган икэл гэх мэт нэршлүүд бий болжээ. Мөн морин хуур болон морин хууртай нэгэн намд багтах хөгжимдүүрүүдийг нутаг бүрд өөр өөрөөр нэрлэж ирсэн уламжлал байна. Жишээлбэл, Хорчинд цоор, Буриадад суух хуур, Шилийн голын цахарт хийл гэх мэтээр нэрлэж иржээ. Иймээс үүнийг харгалзан шинэ цагт урлаж буй гарди толгойтой хуурыг гарди хуур, хун толгойтой хуурыг хун хуур, матар толгойтой хуурыг матар хуур гэж нэрлэж, хэрэглэх нь зүйтэй.

Эдүгээ цагт дэлхий дахины хөгжмийн урсгал чиглэлтэй үндэсний хөгжмөө найрсуулан бүтээлээ туурвиж буй “Алтан ураг”, “Хү”, “Уухай” зэрэг хамтлагууд эдгээр хөгжимдүүрүүдийг дахин сэргээн урлаж, нэрлэж байна. Гэхдээ алийг нь эх үндэс болгож, хуур хэмээх язгуур үндэс нь хадгалагдаж байгаа эсэхийг нягтлан хэрхэн урласнаас нь үүдэн нэрлэх нь зүйтэй. Хөгжимдүүрүүдийн нэршил, тайлбар бүхий сурвалжууд өмнөх өмнөхөөсөө хуулбарлан авсан нь их байгаа бөгөөд шинэ баримт, хэрэглэгдэхүүнээр баяжуулан дэлгэрүүлсэн нь бага байна. Иймээс цаашид шинэ хэрэглэгдэхүүнээр баяжуулан өмнөх судлаачдын судалгааг ахиулахад анхаарах нь зүйтэй.

Номзүй

- Бадраа, Ж. (1998). *Монгол ардын хөгжим*. Улаанбаатар: T&U Printing Co., Ltd
- Бадрах, Г. (2008). *Монголын хөгжмийн түүхээс*. Улаанбаатар: Од свит хэвлэх үйлдвэр. (Анхны хэвлэл 1960).
- Дулам, С. (2009). *Монгол домог зүйн дүр*. Улаанбаатар: Битпресс ХХК-ийн хэвлэлийн газар.
- Мэргэжих, Доржраа, Баянжаргал. (1997). *Монгол дуу хөгжмийн судлал*. Шинжианы ардын хэвлэлийн хороо.
- Соёл, урлагийн их сургуулийн Соёл, урлаг судлалын хүрээлэн. (2018). *Соёл, урлагийн тайлбар толь. Хөгжим IV боть*. Улаанбаатар: “Мөнхийн үсэг” ХХК-ийн хэвлэх үйлдвэр.
- Хэрлэн, Л. (2009). *Монгол ардын хөгжмийн зэмсгийн түүхээс*. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
- Хэрлэн, Л. (2022). *Монгол хөгжмийн зэмсгийн өв соёл*. Улаанбаатар: Удам соёл ХХК-ийн хэвлэлийн газар.
- Цэвэл, Я. (1966). *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо.
- Чулуунцэцэг, Ж. (2008). *Монголын уламжлалт хөгжмийн зэмсэг судлал*. Улаанбаатар: (Хэвлэлийн газар тодорхойгүй)

Abstract

The “Morin Khuur”, one of the traditional musical instruments of the Mongolian nation has been modified and updated over the centuries. Along with this, its name has also changed, and today we mostly use the popular name “Morin Khuur”. On the one hand, it seems to be widely recognized as one of the Mongolian folk musical instruments, and to be known to the world, but there are some shortcomings such as forgetting and not using the previous names, and misinterpreting the differences. On the other hand, we consider it important to reuse the old names of the “Morin Khuur” and similar musical instruments, and to use them for naming newly made musical instruments according to old sources and the era in which they were used. Correct use of names within the framework of its origin is important for the further development and renewal of Mongolian traditional musical instruments. In this article, we intend to explain each of the names created as a result of renewing the “Morin Khuur”, and to suggest some opinions on how to use them.